



ДУНДГОВЬ АЙМАГ
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 2/79

Мандалговь

Г

Бэлчээр чөлөөлөх тухай

Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 “в”, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А-500/283 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бэлчээрийн ургамал сүйтгэгч үлийн цагаан оготнотой мокробиологийн аргаар тэмцэх ажлыг орон нутагт зохион байгуулж байгаатай холбогдуулан бэлдмэл цацахаар заасан бэлчээрийг 2020 оны 04 дүгээр сарын 10-аас 25-ыг хүртэлх 15 хоногийн хугацаатай чөлөөлсүгэй.

2. Бэлдмэл цацаж, тэмцэх ажил зохон байгуулсан талбайгаас мал сүргээ эрүүл нутаг, бэлчээрт гарган бэлчээр чөлөөлөхийг малчдад үүрэг болгосугай.

3. Бэлчээр чөлөөлөх хугацаанд хөдөлмөр хамгаалал, хүн, малын эрүүл ахуйн шаардлагыг хангах талаарх мэдээллийг малчдад хүргэж, зохион байгуулж, хамтран ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Р.МӨНХТОГОХ

